



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Цагдаагийн гудамж, 11 дүгээр хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171  
Утас: 32 05 02, Цахим шуудан: [contact@burtgel.gov.mn](mailto:contact@burtgel.gov.mn),  
Цахим хуудас: [www.burtgel.gov.mn](http://www.burtgel.gov.mn)

10022-12-11 № 1/11664  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
ДЭД САЙД Б.СОЛОНГОО ТАНАА**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын дагуу Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон УБЕГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тайланг хүргүүлж байна.

Хүлээн авна уу.

Хавсралт: ... хуудастай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142316486



11/1/82

УБЕГ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ны  
 өдрийн 1/166У тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН  
 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээ	Төсөв\сая төг\		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтод түвшин		Хэрэгжилт	Хүрсэн түвшин гүйцэтгэлийн хувь
		Төсөвлөсөн	Гүйцэтгэл/Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)		Он	Түвшин	Он	Түвшин		
103	Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөр	-		"Нэг иргэн-Нэг бүртгэл" арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх. Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ.	2022	Хэрэгжилт 85 хувьд хүрсэн байна.	2023 он	Хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна.	Бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia, E-Business/-д 105 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх байсныг давуулан биелүүлж 107 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Дээрх үйлчилгээнүүдээс төрсний бүртгэлийн, гэрлэлт, гэрлэлт цуцалсны, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхийн лавлагаануудыг англи хэл дээр авах боломжтой болов. "E-Mongolia, E-Business" төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар 10,959,863 лавлагаа, үйлчилгээг иргэн, хуулийн этгээд авчээ. Үүнээс: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 7,973,001, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2,558,097, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 428,765 лавлагаа, үйлчилгээ,	100

									англи хэл дээр 407,787 лавлагаа тус тус олгожээ.	
									Засгийн газрын 2023.03.29-ний өдрийн 109 дугаар тогтоолоор Завхан, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст балансаас балансад шилжүүлэх ажлууд зохион байгуулагдсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023.03.28-ны өдрийн 104 дүгээр тогтоол, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022.12.05-ны өдрийн 75 дугаар тогтоолоор Аймгийн Засаг Даргын Тамгын газрын 3 дугаар байрны 580,2 м <sup>2</sup> талбай бүхий хэсгийг Улсын бүртгэлийн хэлтсийн мэдэлд эзэмшүүлж, хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн. Мөн Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2022.09.30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Цагдаагийн газрын хуучин 507.94 мкв байрыг балансаас баланст тусган Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэж 2023.02.13-ны өдөр үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Мөн Дорнод аймгийн УБХ нь ажлын байрны нөхцөл байдал, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг даргад санал хүргүүлснээр шинээр ашиглалтад орсон Нутгийн удирдлагын ордны зүүн жигүүр буюу Б корпуст архивын 2 өрөө, үйлчилгээний 2 танхим, цахим 1 танхим, албан хаагчдын 5 өрөөг тус тус шийдвэрлүүлээ.	
104	Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалт:	-			2022	-	2023	-		100

									<p>Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын сангийн 377, Тамгын газрын архивт 16 нягтруулсан шүүгээг тус тус суурилуулж, өмнө нь хэрэглэж байсан 383 нягтруулсан шүүгээ, 22 төмөр тавиурыг орон нутагт хуваарилан шилжүүлсэн.</p> <p>Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор 9 төрлийн программ хангамж, лицензийн худалдан авч холбогдох тохиргоог хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Oracle Audit Vault and Database Firewall /Мэдээллийн сангийн аудит болон сүлжээнд суурилсан үйл ажиллагааны хяналтын систем/</li> <li>2. Fortigate 300E series firewall 1 year /Сүлжээний галт хана/</li> <li>3. Fortigate 600D series firewall 1 year /Сүлжээний галт хана/</li> <li>4. Spotlight on SQL Server /Мэдээллийн сан, серверийн ачааллын хяналтын системийн лиценз/</li> <li>5. Solarwinds /Сүлжээ, Сервер, Аппликэйшны хяналтын системийн лиценз/</li> <li>6. Microsoft Server 2019 Standard</li> <li>7. Microsoft Exchange Server 2019</li> <li>8. Microsoft Skype for Business Server 2019</li> <li>9. Microsoft System Center Configuration Manager 2021</li> </ol> <p>2023 оны 8 дугаар сараас бүртгэлийн байгууллагын хэмжээнд Microsoft System Center Configuration Manager-ийг ашиглаж эхэлсэн.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--

Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн байрыг дуусган хүлээж авах, ашиглалтад оруулах				2022	80 хувь	2023	100 хувь	Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 2,519,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Мандалт констракшн" ХХК ажиллаж, нийт 938 м/кв зоорийн давхар бүхий дөрвөн давхар барилгыг улсын комисс 2023.12.01-ний өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна.	100
Ховд аймгийн УБХ болон архивын тасгийн байрны барилгын ажлыг гүйцэтгэх				2022	80 хувь	2023	100 хувь	Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянан 2023 оны 02 сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд 26,0 хувийн гүйцэтгэлд 1.333,9 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлт хүргүүлж, барилгын ажлын гүйцэтгэгчээр ГЦЦЭ ХХК ажиллаж, барилгыг улсын комисс 2023.11.20-ны өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна	100
<b>Биелэлтийн дундаж үнэлгээ</b>									<b>100</b>
<b>Оноо</b>									<b>5</b>

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

УБЕГ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ны  
едрийн 11664 тоот албан бичгийн гуравдугаар хавсралт



**"ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**  
Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Биелэлт	Үнэлгээ
<b>ЗУРГАА.ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ</b>				
Зорилт 6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.				
6.1.1	Цахим үндэстэн болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох "E-Mongolia"-д нэвтрүүлсэн төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээг 1000-д хүргэн нэмэгдүүлж, цахим гэрээ хэлцлийг байгуулах нөхцөл бүрдэж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдсэн байна.	Бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia, E-Business/-д 105 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх байсныг давуулан биелүүлж 107 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Дээрх үйлчилгээнүүдээс төрсний бүртгэлийн, гэрлэлт, гэрлэлт цуцалсны, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхийн лавлагаануудыг англи хэл дээр авах боломжтой болов. "E-Mongolia, E-Business" төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар 10,959,863 лавлагаа, үйлчилгээг иргэн, хуулийн этгээд авчээ.Үүнээс:  Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 7,973,001, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2,558,097, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн	100%

			чиглэлээр 428,765 лавлагаа, үйлчилгээ, англи хэл дээр 407,787 лавлагаа тус тус олгожээ.	
6.1.3	Хаягийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх.	Улсын хэмжээнд хаягжуулалтын ажлыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, хэрэгжүүлсэн байна.	“Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан”-г байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/82, А/985 дугаар тушаалаар байгуулсан. 2023 онд нийслэлийн Чингэлтэй дүүрэг, орон нутагт Төв аймгийн Баянчандмань сумын мэдээллийг кадастрын дугаар, хаягийн мэдээллээр тулгахад Чингэлтэй дүүрэгт 43.7%, Баянчандмань суманд 53.9%, Дундговь аймгийн Сайнцагаан суманд ажилласан бөгөөд нэгж талбарын дугаартай нийт 10350 бүртгэлийн хаягийн мэдээллийг ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 11675 хаягийн мэдээлэлтэй шинэ нэгж талбарын дугаараар тулгалт хийхэд 4150 мэдээлэл таарсан.	
6.1.4	Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх.	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй 500 мянга гаруй барилгын зурган болон бүртгэлийн мэдээллийг засварлаж, өгөгдлийн санг байгуулан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын системтэй холбосон дундын мэдээллийн санг байгуулж, салбар хоорондын уялдааг хангасан байна.	Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2023.05.17-ны өдрийн 11/А/46 дугаартай тушаалаар шинэчлэн байгуулагдсан “Хаягийн мэдээллийн системийг нэвтрүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг судлан тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах, салбар хоорондын уялдааг ханган хамтран ажиллах” үүрэг бүхий ажлын хэсэгт ЭХЭУБГазрын дарга гишүүнээр ажиллаж байна. Хаягийн нэгдсэн мэдээллийн санг газрын нэгж талбарын дугаарт суурилан, хуучин, шинэ хаягийг зэрэгцүүлсэн байдлаар үүсгэхээр Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт байгаа хаягийн мэдээллийг тулгах ажил хийгдсээр байна. Уг ажлын хүрээнд хоёр байгууллага хоёр талаасаа мэдээллийн сан үүсгэн улсын бүртгэлийн байгууллагаас орон нутгийн	100%



			<p>кадастрын дугаартай 566822 бүртгэлийн жагсаалт, ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 540364 мэдээллийг байрлуулсан бөгөөд Үндэсний Дата төвд байрлах сервер дээр нэмж дундын мэдээллийн сангийн бүтэц, өгөгдлийн хүснэгт, баганы мэдээллийг оруулахаар тохиролцон ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо хуульд заасан хязгаартай мэдээллийг тухайн байгууллагын үндсэн чиглэл, үйл ажиллагаанд нийцүүлэн "Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ийн дагуу төрийн 125, хувийн хэвшлийн 313 байгууллага нийт 438 байгууллагат 173 төрлийн сервис үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>Эрүүл мэндийн яамны төрөлт, ГЗБГЗЗГ-ын Э, А дугаарын мэдээллийг солилцох сервисийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. 2023.12.10-ны өдрийг хүртэл 62,114 иргэнд регистрийн дугаар, газрын эзэмших гэрчилгээ 63,715 дугаар, ашиглах гэрчилгээ 993 дугаар тус тус олгосон байна</p> <p>Газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаас автоматаар олгодог болсон бөгөөд 2023.12.10-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 64,708 дугаар дундын мэдээллийн сангаас олгосон байна.</p>	
<b>Дундаж үнэлгээ</b>			<b>100%</b>	
<b>Оноо</b>			<b>5</b>	

--oOo--

УБЕГ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн /11664/ тоот албан бичгийн дөрөвдүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (Сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилт (хувиар)
5	4.1.1. Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, "Нэг иргэн-Нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.	6. УБЕГ, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	2020 - 2024	23490.0	2 аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн архив үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах, техник тоног төхөөрөмжөөр хангасан байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 2,519,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Мандалт констракшн" ХХК ажиллаж, нийт 938 м/кв зоорийн давхар бүхий дөрвөн давхар барилгыг улсын комисс 2023.12.01-ний өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянан 2023 оны 02 сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд 26,0 хувийн гүйцэтгэлд 1.333,9 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлт хүргүүлж, барилгын ажлын гүйцэтгэгчээр ГЦЦЭ ХХК ажиллаж, барилгыг улсын комисс 2023.11.20-ны өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын Хуулийн этгээдийн архивын нягтруулсан шүүгээг шинэчилсэн. Өмнө нь ашиглаж байсан 383 ширхэг шүүгээ, 22 төмөр тавиурыг орон нутагт шилжүүлэв. Засгийн газрын 2023.03.29-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор Завхан, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газарт бүртгэлтэй үл хөдлөх	100

					<p>хөрөнгийг эдгээр аймгийн УБХ-т балансаар шилжүүлэх ажлыг зохион байгуулав.</p> <p>ТӨБЗГ-ын 2023.03.28-ны өдрийн 104 дүгээр тогтоол, Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2022.12.05-ны өдрийн 75 дугаар тогтоолоор тус аймгийн ЗДТГ-ын III байрны 580.2м.кв талбайтай хэсгийг УБХ-т эзэмшүүлж, хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэв.</p> <p>ТӨБЗГ-ын шийдвэр болон Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2022.09.30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор тус аймгийн цагдаагийн газрын 507.94 м.кв байрыг УБХ-т балансаар шилжүүлэв. Уг байрыг 49 сая төгрөгөөр засварлаж, 2023.02.13-ны өдрөөс ашиглаж эхлэв.</p> <p>Мөн Дорнод аймгийн УБХ нь ажлын байрны нөхцөл байдал, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг даргад санал хүргүүлснээр шинээр ашиглалтад орсон Нутгийн удирдлагын ордны зүүн жигүүр буюу Б корпуст архивын 2 өрөө, үйлчилгээний 2 танхим, цахим 1 танхим, албан хаагчдын 5 өрөөг тус тус шийдвэрлүүлээ.</p>	
6	7. Иргэний улсын бүртгэлийн дугаар болон тоон гарын үсгийг улсын болон төрөлжсөн бүртгэлийн үйлчилгээнд бүрэн нэвтрүүлэн, бүртгэлжүүлнэ.	2020 - 2024	5791.0	<p>Иргэний улсын бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээний тоон гарын үсгийн ашиглалтыг 10 хувьд хүргэсэн байна.</p>	<p>Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг боловсруулж ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Тус хуулийн төсөл 2022.06.03-ны өдөр батлагдсанаар хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах ажил шинэ шатанд гарав. Тухайлбал, Иргэний регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн мэдээлэл зэргийг иргэний үнэмлэхийн санах ойд байршуулж, иргэний талаар ямар нэгэн мэдээлэл агуулаагүй, дахин давтагдахгүй иргэний бүртгэлийн дугаарыг иргэний үнэмлэх дээр ил харагдах байдлаар бичиж, төрийн үйлчилгээг авахад уг дугаарыг ашиглах боломж бүрдэв.</p> <p>Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг Монгол Улсын Засгийн газрын 2022.10.10-ны өдрийн "Монгол Улсын иргэний үнэмлэхийн</p>	100

					<p>тодорхойлолт, загварыг шинэчлэн батлах тухай” 374 дүгээр тогтоолоор батлуулж, иргэний үнэмлэх дээр регистрийн дугаарын оронд иргэний бүртгэлийн 12 оронтой дугаарыг ил харагдах байдлаар бичих ажлыг 2022.12.13-ны өдрөөс эхлүүлэв. Энэ оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 273,410 иргэнд шинэ загварын иргэний үнэмлэх олгосон байна.</p> <p>Төрийн мэдээлэл солилцооны (ХУР) систем дэх улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж буй бүх сервист өөрчлөлт оруулж, төрийн болон бусад байгууллага иргэний улсын бүртгэлийн дугаараар мэдээлэл авах боломжтой болсон. Мөн Монгол Улсад төрсөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын харьяат болсон иргэний улсын бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хөтөлж, тухай бүр мэдээллийн сангаас иргэний бүртгэлийн дугаарыг шууд олгож байна. Харин иргэний харьяаллыг сэргээн тогтоосны бүртгэл хөтөлсөн тохиолдолд тухайн иргэний бүртгэлийн дугаарыг мэдээллийн сангаас сэргээж, ашиглах боломжтой болов. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу иргэнд иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан цахим шуудангийн хаяг нээсэн. Ингэснээр хуулийн хэрэгжилтийг хангаж, хүний хувийн мэдээллийг хамгаалах боломж сайжрав. БШУЯ, НХХЯ, ҮСХ, ЗТХЯ, ТатЕГ, НДЕГ болон ХААН,ХХБ, Капитрон банк зэрэг байгууллагын иргэний регистрийн дугаарыг ашиглан үйлчилгээ үзүүлдэг мэдээллийн санг шинэчилж, иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангаж, сонгогчдын нэрийн жагсаалт</p>
--	--	--	--	--	--

					болон сонгогчийн ирц бүртгэлийн программд сонгогчийн иргэний бүртгэлийн дугаарыг оруулахаар хөгжүүлэлт хийв. Энэ оны 12 дугаар сарын 10-ны байдлаар хүсэлт гаргасан 948,668 иргэнд тоон гарын үсэг олгосноос: -Иргэний үнэмлэхэд 763,597 -Гар утасны аппликэйшнээр 185,134 тоон гарын үсэг олгожээ.	
7	8. Иргэний үнэмлэхийн үйлдвэрийг өргөтгөн гадаад паспортын бэлдэцэд бичилт хийх үйлдвэрийн бүтцийг УБЕГ-т байгуулж, үндэсний цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлнэ.	2020 - 2024	10313.0	Үндэсний гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн ажлыг хэвийн үргэлжлүүлж, үндэсний цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн байна.	“Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспортын бэлдэцэд бичилт хийх үйлдвэрийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг УБЕГ-ын даргын 2022.09.15-ны өдрийн А/1145 дугаар тушаалаар батлав. Үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн байрыг олон улсын стандартын дагуу засварлаж, тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулан 2022.10.01-ний өдрөөс ажиллуулж эхлэв. 2022.10.01-2023.12.10-ны өдрийн байдлаар 585,634 иргэн гадаад паспорт авах хүсэлт гаргасан. Үүнээс энгийн гадаад паспорт авах 309,716, цахим гадаад паспорт авах 275,918 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүрэн шийдвэрлэсэн.	100
	9. Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ.				Бүртгэлийн байгууллагын үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр үзүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг хүртээмжтэй, хялбар хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал ( <i>E-Mongolia, "E-Business"</i> )-д 105 төрлийн үйлчилгээ нэвтрүүлэхээс тайлант хугацаанд 107 төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Мөн дээрх үйлчилгээнүүдээс төрсний бүртгэлийн, гэрлэлт, гэрлэлт цуцалсны, гэрлэлт дуусгавар болсны, иргэний үнэмлэхийн лавлагаануудыг англи хэл дээр авах боломжтой болов.	100

					<p>"E-Mongolia, E-Business" төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар 2020-2023 оны 12 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 10,959,863 лавлагаа, үйлчилгээг иргэн, хуулийн этгээд авчээ. Үүнээс:</p> <p>Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 7,973,001, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2,558,097, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 428,765 лавлагаа, үйлчилгээ, англи хэл дээр 407,787 лавлагаа тус тус олгожээ.</p> <p>Цахим хөгжил, харилцаа холбооны яам (ЦХХХЯ)-наас 2023.02.08-ны өдөр зохион байгуулсан И-Бизнесийг хөгжүүлэх, цахимаар хуулийн этгээдийг бүртгэхтэй холбоотой асуудлаар ЦХХХЯ, Голомт банкттай гурван талт уулзалт хийв.</p> <p>Улсын бүртгэлийн "ДӨТ" машинаар иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээний талаар "Нью компас" ХХК-ийн төлөөлөлтэй уулзаж, холбогдох саналыг хүргүүлэв. Энэ ажлын хүрээнд "ДӨТ" машинаар гадаад паспорт, иргэний үнэмлэх дахин авах болон шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хийхээр хөгжүүлэлт хийв.</p>	
8		10. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран хаягийн нэгдсэн мэдээллийн сантай болно.	2020 - 2024	-	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ)-ын дарга нарын 2023.05.15-ны өдрийн А/82, А/985 дугаар хамтарсан тушаалаар Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн санг байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. 2023 онд нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Төв аймгийн Баянчандмань сумын мэдээллийг кадастрын дугаар, хаягийн мэдээллээр тулгахад Чингэлтэй дүүрэгт 43.7%, Баянчандмань суманд 53.9%-ийн нийцэлтэй байна. Түүнчлэн тус ажлын хэсэг Дундговь аймгийн Сайнцагаан суманд ажилласан бөгөөд нэгж</p>	

					<p>талбарын дугаартай 10,350 бүртгэлийн хаягийн мэдээллийг ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 11,675 хаягийн мэдээлэлтэй тулгахад 4,150 мэдээлэл нийцэж байв. Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2023.05.17-ны өдрийн 11/А/46 дугаартай тушаалаар шинэчлэн байгуулагдсан "Хаягийн мэдээллийн системийг нэвтрүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг судлан тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах, салбар хоорондын уялдааг ханган хамтран ажиллах" үүрэг бүхий ажлын хэсэгт УБЕГ-ын ЭХЭУБГ-азрын дарга ажиллаж байна.</p> <p>Хаягийн нэгдсэн мэдээллийн санг газрын нэгж талбарын дугаарт суурилан, хуучин, шинэ хаягийг зэрэгцүүлсэн байдлаар үүсгэхээр УБЕГ, ГЗБГЗЗГ-т байгаа хаягийн мэдээллийг тулгах ажил үргэлжилж байна. Уг ажлын хүрээнд УБЕГ-аас орон нутгийн кадастрын дугаартай 566,822 бүртгэлийн жагсаалтыг, хоёр байгууллага хамтран мэдээллийн сан үүсгэж, улсын бүртгэлийн байгууллагаас, ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 540,364 мэдээллийг байрлуулсан бөгөөд Үндэсний Дата төв дээр виртуал сервер бүхий дундын мэдээллийн санг 19 багана бүхий хаягийн мэдээлэлтэйгээр үүсгэсэн. Энэ нь орон нутагт байгаа нийт хаягийн бичлэгийн 92.6%-ийг эзэлж байна.</p>	100
9	11. Мэдээлэл солилцох болон дундын мэдээллийн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар Улсын бүртгэлийн	2020 - 2024	-	Улсын бүртгэлийн мэдээлэл солилцоо болон дундын мэдээллийн сангийн хэрэглээ	<p>Газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаас автоматаар олгодог болсон бөгөөд 2023.12.08-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 64,708 дугаар дундын мэдээллийн сангаас олгосон байна.</p> <p>Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх ажлын</p>	100

		мэдээллийг төрөлжсөн бүртгэлд ашиглана.			нэмэгдсэн байна.	<p>хүрээнд УБЕГ-ын дарга Д.Дэлгэрсайхан, Монголын Нотариатчдын танхимын ерөнхийлөгч Ч.Баянжаргал нар 2023.11.22-ны өдөр Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээг байгуулсан. Үүний үндсэн дээр одоогийн байдлаар Монголын нотариатчдын танхимын 89 нотариатчтай мэдээлэл солилцох гэрээг байгуулсан. Монголын нотариатчдын танхим болон "Интерактив" ХХК нотариатын зуучлалын системийг хөгжүүлж байгаа ба УБЕГ-аас API болон орчны тохиргооны мэдээлэл, шаардлагатай сервисүүд, нэвтрэх нэр, нууц үгийг үүсгэж өгсний дагуу системийг ашиглахад бэлэн болоод байна.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо хуульд заасан хязгаартай мэдээллийг тухайн байгууллагын үндсэн чиглэл, үйл ажиллагаанд нийцүүлэн "Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ийн дагуу төрийн 125, хувийн хэвшлийн 313 байгууллага нийт 438 байгууллагат 173 төрлийн сервис үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>Эрүүл мэндийн яамны төрөлт, ГЗБГЗЗГ-ын Э, А дугаарын мэдээллийг солилцох сервисийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. 2023.12.10-ны өдрийг хүртэл 62,114 иргэнд регистрийн дугаар, газрын эзэмших гэрчилгээ 63,715 дугаар, ашиглах гэрчилгээ 993 дугаар тус тус олгосон байна</p>	
11	4.2.1. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх	1. Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх	2021 - 2024	-	Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох,	<p>УБЕГ-ын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, видео, нийтлэл, зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг 9 удаагийн давтамжаар</p>	100



<p>хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.</p>	<p>хөтөлбөр хэрэгжүүлж, авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгоно.</p>			<p>урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ</p>	<p>УБЕГ-ын 23 нэгжийн цахим болон пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлах арга хэмжээ авав. Тус хуудсанд мэдээлэл авах хандалт 72,709, like 427, share 251 байна.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-д заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийг <a href="http://www.opendata.burtgel.gov.mn">www.opendata.burtgel.gov.mn</a> сайтад байршуулж, олон нийтийн хяналт тавих боломжийг сайжруулав.</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, байршуулсан мэдээллийг хуулийн хугацаа, үнэн, зөв байршуулсан эсэхэд сар бүр хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шүгэл" ажиллагааны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж "шүгэл үлээх"-ийг уриалсан соён гэгээрүүлэх аяны хүрээнд УБЕГ-ын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд постер, шторк байрлуулав.</p> <p>Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр үйлчлүүлэгч бүртгэгчийн шууд харилцаа багасаж авлигад өртөх эрсдэл буурсан гэж үзэж байна.</p> <p>Шинээр томилогдсон улсын бүртгэгчдэд "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулж 81 албан хаагч хамруулсан.</p> <p>АТГ-аас 2023.06.21-нд УБЕГ-ын болон салбар нэгжийн улсын бүртгэгч нарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын талаар ээлжит сургалтыг зохион байгуулж 76 албан хаагч оролцсон.</p>
---	---	--	--	---	---

12	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2021 - 2024	-	Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээг шалгуур болгож байна. Ашиг сонирхлын зөрчлийн болон ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг утсаар, <a href="http://www.burtgel.gov.mn">www.burtgel.gov.mn</a> , <a href="mailto:contact@burtgel.gov.mn">contact@burtgel.gov.mn</a> хаягаар болон бичгэн хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэж байна. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", УБЕГ-ын даргын 2020 оны А/1510 дугаар тушаалаар батлагдсан "Улсын бүртгэлийн ерөнхий газрын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-ын дагуу УБЕГ-ын Ёс зүйн зөвлөлийг байгуулж, албан хаагчдыг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Мөн "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-ийн танилцуулгыг улсын бүртгэлийн байгууллагын нийт 953 албан хаагчдад танилцуулж, төстийн шалгалт авсан бөгөөд дундаж үнэлгээ 85 хувь.	100
<b>Биелэлтийн дундаж үнэлгээ</b>							<b>100%</b>
<b>Оноо</b>							<b>5</b>



УБЕГ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн /1664/ тоот албан бичгийн тавдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Улаанбаатар хот

2023 оны 12 дугаар сарын 11 өдөр

№	Зорилт /Бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2023 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч	Хамтран хариуцагч	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Хэрэгжилт	Үнэлгээ
			Суурь түвшин	Зорилтот түвшин	Хөрөнгийн хэмжээ /сая.төг/	Эх үүсвэр					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
<b>Бүлэг 3. Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого</b>											
Зорилго 3.1. Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлнэ.											
3.1.1	МУХТЖУ 4-5.3.2, 5.3.4, ЗГҮАХ- 3.1.11, 4.1.1, 4.1.3, 4.5.1, 4.5.3	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	5.5	50		Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайд		28 сая	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022.05.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Монгол Улсын насанд хүрсэн 2.2 сая иргэнд тоон—гарын үсэг олгох ажлыг хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд энэ оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 948,668 иргэнд тоон гарын үсэг олгов. (Иргэний үнэмлэхэд 763,597, Гар утасны аппликэйшнээр 185,134 хүн) Хилийн чанад дахь 7 ДТГ-аар дамжуулан иргэдэд цахим гарын үсэг олгох ажлыг эхлүүлсэн ба цаашид үүнийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Иргэд тоон гарын үсэг ашиглаж эхэлснээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж нь сайжрав.	100

			"Цахим архив, албан хэрэг хөтлөлт" арга хэмжээн ий хэрэгжилт, хувиар	30		Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Архивын ерөнхий газар	0,004	ХЗДХЯ-ны харьяа байгууллагууд Архив, албан хэрэг хөтлөлтийн "eDoc" нэгдсэн системийг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан УБЕГ-ын бүх салбар нэгж үйл ажиллагаандаа нэвтрүүлэв. Тус системээр 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 11,642 албан бичгийг иргэн, хуулийн этгээдэд явуулж, 20,165 албан бичгийг хүлээн авчээ.	100
		Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/ суурилуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	5,000.0	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайд		45,0	Бүртгэлийн үйлчилгээний 67 ширхэг цахим машин /ДӨТ/-ыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, ашиглалтад оруулсан ба 26 төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Үүнд: • 18 төрлийн лавлагаа (Иргэний улсын бүртгэл-12, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-4, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-2) • 8 төрлийн үйлчилгээ (Иргэний улсын бүртгэл-4, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-3) Мөн гадаад паспорт захиалгын 10 ширхэг "ДӨТ" машины программ хангамжийг хөгжүүлж, угсарч байна. Монгол Улсын иргэдэд олгох тоон гарын үсгийг бусад байгууллагын 1,270 ширхэг цахим машин /киоск/-аар олгодог болов. Үүнд: -Гэрэгэ системс ХХК-385 -Голомт банкны АТМ-аар -270 -ХААН банкны АТМ-аар-480	100

										-ТҮЦ машин-135	
		Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар		100	12,900.0	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайд	Архивын ерөнхий газар		Мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ, сервер тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023.04.18-ны өдрийн А/831 дүгээр тушаалаар "НЭГ ИРГЭН-НЭГ БҮРТГЭЛ үндэсний хөтөлбөрийн хүрээнд худалдан авахаар төлөвлөж буй улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн сервер, сүлжээ, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023.05.17-ны өдрийн А/986 дугаар тушаалаар "Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн сервер, сүлжээ, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах программ хангамжийн лицензийг хүлээн авах, данс бүртгэлд тусгах" үүрэг бүхий Ажлын хэсэг тус тус байгуулагдан Н-2023/15 дугаар гэрээг байгуулан дараах программ хангамжуудын албан ёсны эрхийг авч суурилуулсан.Үүнд: 1. Oracle Audit Vault and Database Firewall /Мэдээллийн сангийн аудит болон сүлжээнд суурилсан үйл ажиллагааны хяналтын систем/	100



УБЕГ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн /.../ тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт



**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Шийдвэр д/д	Заалт д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ (Хувиар)
<b>Монгол Улсын хууль</b>					
33	85	Улсын бүртгэлийн ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ 2018-06-21 Дугаар 2018.06.21	5.3. Энэ хуулийн 5.2-т зааснаас бусад хуульд заасан бүртгэл нь төрөлжсөн бүртгэлд хамаарах бөгөөд бүртгэлийн жагсаалтыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2023 оны 164 дугаартай тогтоолын хавсралтаар "Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт" батлагдсанаар Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн заалт хэрэгжсэн тул дээрх төлөвлөгөөнөөс уг арга хэмжээг хасах саналыг хүргүүлж байна.	100
			6.9. Улсын бүртгэлийн байгууллага Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ олгоно.	Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021.12.17-ны өдөр батлагдаж, 2022.05.01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор ХААН банкттай хамтран аян зохион байгуулж байгаагийн зэрэгцээ тоон гарын үсэг олгох программ хангамжийг хөгжүүлж пин код солих, өмнөх тоон гарын үсгийн мэдээллийг хүчингүй болгох зэрэг функцийг нэвтрүүлэхээр "Тридум кэй" ХХК-тай хамтран ажиллаж байна. Тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд, улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /ДӨТ/-аар, гар утасны аппликэйшнээр олгож байна. Иргэдэд тоон гарын үсэг олгосноор төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia.mn/-ээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн. УБЕГ-аас 21 аймаг, 9 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр дамжуулан Монгол	100

				<p>Улсын 16 ба түүнээс дээш насны 2.2 сая хүнд тоон гарын үсэг олгохоос хүсэлтийн дагуу 2023.12.10-ны байдлаар тоон гарын үсэг авах хүсэлт гаргасан 948,668 иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээ, хувийн түлхүүрийг иргэний үнэмлэхний санах ой болон гар утасны аппликэйшнд байршуулсан. Үүнд:</p> <p>-Иргэний үнэмлэхэд-763,597</p> <p>-Гар утасны аппликэйшнээр-185,134</p> <p>Мөн үеийн байдлаар хилийн чанад дахь Монгол Улсын 83 иргэнд тоон гарын үсэг олгоод байна. (АНУ-д 55, БНСУ-д 25, Канад улсад 3)</p>	
36	98	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/ 2018-06-21 Дугаар 2018.11.01</p>	<p>10.9. Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Засгийн газар батална.</p>	<p>"Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам"-ын төслийг УБЕГ-аас боловсруулан, танилцуулгын хамт 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 1/7093 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/277 дугаар тушаалаар "Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам"-ын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт УБЕГ-ын дарга Д.Дэлгэрсайхан, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд, Эрх зүйн хэлтсийн дарга Б.Хэрлэнчимэг нар ажиллаж байна. Журмын төсөлд төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн эзэмших, ашиглах эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг дундын мэдээллийн сангаар дамжуулан цахимаар бүртгэхээр зохицуулсан. Дундын мэдээллийн сангаар дамжуулан цахимаар бүртгэх боломжтой эсэх, төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээллийн системийн нөхцөл байдал, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн тоон мэдээлэл, тооллогын мэдээллийн бүтцийн талаар холбогдох мэдээлэл ирүүлж, хамтарч ажиллах тухай 2023.10.27-ны өдрийн 1/9966 дугаар албан бичгийг ТӨБЗГ-т хүргүүлээд байна.</p> <p>Өнөөдрийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээллийн систем хөгжүүлэх ажил хийгдэж байна.</p>	100



Засгийн газрын тогтоол					
36	44	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_160	1.4. "Хуашен констракшн Монгол" ХХК-ийн хөрөнгө оруулагчийг залилсан, улсын бүртгэлийн үйл ажиллагаа хууль зөрчсөн талаарх гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт;	"Хуашен констракшн Монгол" ХХК-иас 2023.03.31-ний өдөр ХЗДХЯ-нд гаргасан гомдол, мөн тус газарт 2023.05.04-ний өдрийн 23/23 дугаар албан бичгээр ирүүлсэн гомдолтой холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйл, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 8.4-т зааснаар хяналт шалгалт хийж, илэрсэн нөхцөл байдлыг шалгуулахаар холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэв.	100
36	45		2. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	"Хуашен констракшн Монгол" ХХК-ийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөнийг бүртгэсэн 2021.05.04-ний өдрийн бүртгэлийн нотлох баримтад авагдсан 2021.04.09-ний өдрийн Компанийн эрх шилжүүлэх болон Хувьцаа худалдах, худалдан авах гэрээнд зурагдсан "Хуашен констракшн Монгол" ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшигч, БНХАУ-ын иргэн Hang Feilong, компанийн гүйцэтгэх захирал, БНХАУ-ын иргэн Zhang Dong нарын гарын үсэг хуурамч, тухайн гэрээ хийгдэх үед дээрх 2 иргэн Монгол Улсад байхгүй зэрэг нөхцөл байдал тогтоогдсоныг, мөн эрхийн улсын бүртгэлийн Y-2203024452 дугаартай, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн нотлох баримт болох 2015.08.21-ний өдрийн хэлцэлд гомдол гаргагч "Хуашен констракшн Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал БНХАУ-ын иргэн Zhang Dong-ийн зурагдсан гарын үсэг болон ХТА 2573 дугаартай тэмдэг хуурамч гэх мэдээллийг шалгуулах, шинжилгээ хийлгүүлэхээр 2023.05.22-ны өдрийн 6/4957 дугаар, 2023.06.20-ны өдрийн 6/5993 дугаар албан бичгийг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтэст тус тус хүргүүлэв. УБЕГ-ын даргын 2023 оны А/442 дугаар тушаалаар байгуулагдсан "Хуашен констракшн монгол" ХХК-иас ирүүлсэн гомдлыг шалгаж,	100

				<p>дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн тайланг баримтын хамт 2023.05.16-ны өдрийн 6/4688 дугаар албан бичгээр, Ү-2203024452 дугаар бүртгэлтэй холбогдуулан хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг хамтатган шалгуулахаар 2023.05.22-ны өдрийн 6/4956 дугаар албан бичгээр холбогдох нотлох баримтуудыг АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст хүргүүлсэн байна.</p> <p>ХЗДХСайд Х.Нямбаатарт 2023.09.15-ны өдрийн 1/8293 дугаар албан бичгээр Шүүх шинжилгээний болон Цагдаагийн байгууллагад Ү-2203024452 дугаар эрхийн улсын бүртгэлийн холбоотой хийгдэж буй ажлыг эрчимжүүлэх, дэмжлэг хүсэх талаар хүсэлт хүргүүлсэн. Мөн ЦЕГ-ын Тэргүүн дэд дарга Ц.Ням-Очирт 2023.09.27-ны өдрийн 1/8713 дугаар албан бичгээр Шинжээчийн дүгнэлт ирүүлэх болон Ү-2203024452 дугаартай эрхийн улсын бүртгэлийн нотлох баримтын гарын үсгийн үнэн зөвийг шинжлэн өгөхөд хамтран ажиллах талаар хүсэлтийг хүргүүлсэн. Хамтран ажиллах тухай албан бичгийн хүрээнд СБД-ийн Цагдаагийн газрын I хэлтсийн 2023.10.26-ны 28иа/6727 дугаар албан бичигт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шинжээчийн дүгнэлтийг хүргүүлэх боломжгүй мөн 2015 оны 08 дугаар сарын Хуашенконстракшн Монгол ХХК болон Аюуд ХХК-ийн хамтарсан хурлын шийдвэр, хамтран өмчлөгч хасагдах хэлцэлтэй холбоотой асуудал нь гэмт хэргийн шинжтэй гэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул хэргийг хаах саналтай СБД-ийн Прокурорын газарт хүргүүлснийг 2023.10.27-ны өдрийн 1627 дугаартай тогтоолоор хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн байна.</p> <p>Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг үндэслэн 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гомдол гаргагч талуудыг оролцуулан сонсох ажиллагааг УБЕГ-ын дарга, Улсын ерөнхий байцаагч Д.Дэлгэрсайхан удирдан зохион байгуулсан.</p> <p>Дээрх гомдолтой холбогдуулан хийсэн хяналт шалгалтын хүрээнд тус компанийн захирал Zhang Dong өмгөөлөгч Э.Ганхөлөг нарт 2023.04.12-ны өдрийн 1/3346 албан бичиг, 2023.05.23-ны өдрийн 6/4065 албан бичиг, 2023.08.09-ний өдрийн хяналтын улсын байцаагчийн 5012 дугаар дүгнэлт, 2023.11.06-ны өдрийн 1/10272</p>
--	--	--	--	--

				албан бичгээр гомдолд дурдсан шаардлагыг хангаж шийдвэрлэх боломжгүй тухай хариу өгч байна.	
11	13	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_413	2.2."Монгол Болгар гео" ХХК-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбогдох гомдлыг хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан)-т;	"Монгол болгар гео" ХХК-ийн 50 хувийн хувьцаа эзэмшигч Д.Лхагвасүрэнгээс тус газарт 2022.01.28-ны өдөр 50 хувийн хувьцаа эзэмшигч "Болграгеомин нэгдэл" компанийг хасуулах тухай гаргасан хүсэлт болон ТӨБЗГ-ын А-1/213 дугаар албан бичгийг судлан үзээд 2022.02.10-ны өдөр улсын бүртгэлд бүртгэж, хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн. Тус компанийн асуудлаар УБЕГ-т төлөөлөх эрх бүхий этгээдээс гомдол, хүсэлт өнөөдрийн байдлаар ирүүлээгүй байна.	100
			3. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	Мөн гадаадын хөрөнгө оруулагчдаас тус газарт Засгийн газрын иргэд, олон нийттэй харьцах 11-11 төвд 2023 оны байдлаар 3 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч танилцаад ажлын 8 цагт багтаан шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн. Ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлттэй танилцахад гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг ажлын 10 өдөрт бүртгэж байгаа нь цаг хугацааны хувьд удаан бөгөөд түргэн шуурхай шийдвэрлэхгүй байна гэх утгатай байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 21.6-д ажлын 10 өдрийн дотор бүртгэнэ гэж заасан байдаг. Иймд тухайн заалтыг ажлын 5 өдөр байхаар өөрчлөх санал гаргаж, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж байгаа ажлын хэсэгт хүргүүлсэн.	100
27	33	Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах тухай 2023-02-08 Дугаар	4.."Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийг улсын бүртгэлд бүртгүүлж, компанийн үйл	Засгийн газрын 2023.02.08-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц үйлдвэрлэх, бичилт хийх "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлагдсан. "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 51 хувийн хувьцаа эзэмшигчээр, "Мигасон" ХХК нь	100

		2023_69	ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Дэлгэрсайхан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.	49 хувийн хувийн хувьцаа эзэмшигчээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023.04.11-ны өдөр "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК бүртгэгдсэн. "Хэвлэх үйлдвэр"-т 2023.03.01-2023.12.10-ний өдөр хүртэл шинэ бэлдцээр хэвлэгдсэн нийт 410,694 паспорт байна. Үүнээс энгийн гадаад паспорт 134,776, цахим гадаад паспорт 275,918 байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хэвлэх үйлдвэр иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэн, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийж, 2023.12.10-ны өдрийн байдлаар 273,410 иргэний үнэмлэх хэвлэж, 585,634 үндэсний энгийн гадаад паспортын бичилтийг хийсэн байна.	
<b>Засгийн газрын хуралдааны тэмдэглэл</b>					
60	71	2022 оны 04 дүгээр сарын ᠙ны өдөр  21 дүгээр тэмдэглэл 2022-04-08 Дугаар 2022_21	I.1.10. Сонгуулийн автоматжуулсан систем, УИХ-ын гишүүний халдашгүй бүрэн эрхтэй холбоотой асуудлыг судлан үзэж, УИХ, холбогдох Байнгын хороотой санал солилцож танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт;	Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сонгогчийг бүртгэх, түүнийг таних техник хэрэгслийн иж бүрдлийн жагсаалт, техникийн үзүүлэлт, тоо ширхгийг тодорхойлж, тоног төхөөрөмжийг шинэчлэх тухай албан бичгийг 2022.02.08, 2022.03.09, 2022.04.12-ны өдрүүдэд СЕХ-нд хүргүүлсэн. 2023 оны төсвийн тодотголоор тус байгууллагын хөрөнгө оруулалтын зардалд 18,5 тэрбум төгрөг батлагдсан. Худалдан авах ажиллагааг УБЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажилласан. Гэрээний дагуу санхүүжилтыг олгохоор ХЗДХЯ-нд албан бичгээр хүргүүлсэн. УИХ-ын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүн, УИХ-ын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нараас 2023.04.05-ны өдөр УИХ-д өргөн барьсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбоотой ажилд идэвхтэй оролцон ажиллав. Улмаар дээрх хуулийг УБЕГ-ын албан хаагчдад танилцуулах сургалтыг 2023.10.25-ны өдөр зохион байгуулсны зэрэгцээ УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар УБЕГ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төслийг бэлтгэж байна.	100

				УБЕГ-ын даргын 2023.03.22-ны өдрийн А/600 тоот тушаалаар зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахад оролцох бэлтгэлийг хангах Ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг нь батлав. Улмаар төлөвлөгөөт ажлуудыг СЕХ-ны "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь"-тай нийцүүлж, бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2023 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахад УБЕГ-аас чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж, үүнд тус байгууллагын нийт 149 ажилтан оролцов.	
71	88	2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл 2022-10-19 Дугаар 2022_50	<p>ХII.3.2. Хилээр нэвтэрсэн болон улсын бүртгэл, нийгмийн даатгал, татварын байгууллагад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох талаар зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар "Үндэсний системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглах үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам" батлагдсан. Энэ журмын хүрээнд суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас үндсэн болон дэмжих системд мэдээлэл нийлүүлэх, үндсэн болон дэмжих системээр дамжуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд үйлчилгээ авах, хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар мэдээлэл солилцох үндсэн систем нь "Хур" систем юм. "Хур" системын гэрээг Цахим хөгжил, харилцааны холбооны яам хариуцан төрийн байгууллагуудтай хийж байна. Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагууд тус яамтай гэрээ байгуулан улсын бүртгэлийн мэдээллийг үйл ажилланаандаа ашиглаж байна. Улсын бүртгэлийн асуудлаар төрийн болон бусад байгууллагатай мэдээлэл солилцох ХУР систем болон дундын мэдээллийн сангийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.</p>	100
<b>Биелэлтийн дундаж үнэлгээ</b>				100%	
<b>Оноо</b>				<b>5</b>	

УБЕГ-ын 2023 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 11/11664 тоот албан бичгийн зургаадугаар хавсралт



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ.</b> "Алсын хараа-2050" зорилт 5.3, 7.4, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, 7.4, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/							
<b>Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</b>							
1.1	Хоёр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв 3.269,6 сая.төг /Ховд/ 1.249,9 сая.төг /Хэнтий/	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	70	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 2,519,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Мандалт констракшн" ХХК ажиллаж, нийт 938 м/кв зоорийн давхар бүхий дөрвөн давхар барилгыг улсын комисс 2023.12.01-ний өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянан 2023 оны 02 сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд 26,0 хувийн гүйцэтгэлд 1.333,9 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлт хүргүүлж, барилгын ажлын гүйцэтгэгчээр ГЦЦЭ ХХК ажиллаж,	100

						<p>барилгыг улсын комисс 2023.11.20-ны өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Засгийн газрын 2023.03.29-ний өдрийн 109 дугаар тогтоолоор Завхан, Өвөрхангай, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг Улсын бүртгэлийн хэлтэст балансаас балансад шилжүүлэх ажлууд зохион байгуулагдсан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023.03.28-ны өдрийн 104 дүгээр тогтоол, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022.12.05-ны өдрийн 75 дугаар тогтоолоор Аймгийн Засаг Даргын Тамгын газрын 3 дугаар байрны 580,2 м<sup>2</sup> талбай бүхий хэсгийг Улсын бүртгэлийн хэлтсийн мэдэлд эзэмшүүлж, хөрөнгөд бүртгэхээр шийдвэрлэсэн. Мөн Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022.09.30-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Цагдаагийн газрын хуучин 507.94 мкв байрыг балансаас баланст тусган Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэж 2023.02.13-ны өдөр үйл ажиллагааг нь жигдрүүлсэн.</p> <p>Мөн Дорнод аймгийн УБХ нь ажлын байрны нөхцөл байдал, албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор Аймгийн Засаг даргад санал хүргүүлснээр шинээр ашиглалтад орсон Нутгийн удирдлагын ордны зүүн жигүүр буюу Б корпуст архивын 2 өрөө, үйлчилгээний 2 танхим, цахим 1</p>
--	--	--	--	--	--	--

						танхим, албан хаагчдын 5 өрөөг тус тус шийдвэрлүүллээ.	
1.2	Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх.	Улсын төсөв 4.800 сая.төг	Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх гүйцэтгэлийн хувь	40	100	Монгол Улс 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдөр ICAO PKD (Олон улсын Иргэний нисэхийн байгууллагын аяллын цахим баримт бичгийн нийтийн түлхүүрийн мэдээллийн сан) -ийн 82 дахь гишүүн орноор албан ёсоор элсэн орж ICAO-оос батлан гаргасан чилтэй цахим гадаад паспортын стандартыг хангасан (ICAO DOC-9303) олон улсад хүчин төгөлдөр байх гадаад паспортыг нэвтрүүлэх боломжтой болсон. Нийтийн түлхүүрийн дэд бүтэц буюу гадаад паспортыг хэвлэлтийн явцад зурж, баталгаажуулах үүрэг бүхий цахим гарын үсгийн системийг ажиллагаанд оруулан уг системийг ICAO PKD (Олон улсын Иргэний нисэхийн байгууллагын аяллын цахим баримт бичгийн нийтийн	100



						<p>түлхүүрийн мэдээллийн сан)-ийн олон улсын сантай холбосон.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 4.1.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний 8, Монгол Улсын Засгийн газрын 2022.04.13-ны өдрийн "Үндэсний гадаад паспортын загвар, тодорхойлолт батлах тухай" н/155 дугаар тогтоолоор батлагдсан загвар, тодорхойлолтын дагуу энгийн гадаад паспорт /цахим/-ыг нэвтрүүлж, олгох ажлыг 2023.03.01-ний өдрөөс эхлүүлэн УБЕГ-ын даргын 2023 оны А/01 дугаар тушаалаар байгуулагдсан "Энгийн гадаад паспорт /цахим/-ыг нэвтрүүлж, олгох ажлыг хангах, эхлүүлэх, жигдрүүлэх, түүнтэй холбоотой бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Хэвлэх үйлдвэрт үндэсний энгийн гадаад паспорт хэвлэж эхэлсэнтэй холбоотойгоор "Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулж, холбогдох саналыг нэгтгэн Монгол Улсын Засгийн газрын 2023.02.08-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор батлуулсан. Мөн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018.04.05-ны өдрийн А/394</p>
--	--	--	--	--	--	--

						<p>дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Улсын бүртгэлийн байгууллагаас үндэсний энгийн гадаад паспорт, хил орчмын нутагт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох, гадаадад зорчих эрхийн бүртгэл хөтлөх журам"-ын 3.5, 3.6, 3.11,3.12, 4.1, 4.6, 9.2, 9.3 дахь хэсэгт 2022 оны УБЕГазрын даргын А/1194 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.</p> <p>Хэвлэх үйлдвэрт үндэсний энгийн гадаад паспорт /цахим/-ыг 2023.03.01-ний өдрөөс хэвлэж эхэлсэн бөгөөд 2023.12.10-ны өдрийн байдлаар 275,918 ширхэг үндэсний энгийн цахим гадаад паспортыг хэвлэн иргэдэд олгосон байна.</p>	
1.3	Тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах	-	Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	22	50	<p>Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021.12.17-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар баталж 2022.05.01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газраас Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны 2,2 сая иргэддээ тоон гарын үсгийг 21 аймаг, 9 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр олгож эхэлсэн бөгөөд иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд, улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /ДӨТ/-аар, гар утасны аппликэйшаар олгож байна.</p> <p>Мөн 2023 онд байдлаар гадаад улсад оршин сууж байгаа Монгол Улсын 83 иргэнд тоон гарын үсэг олгоод байна. /Америкийн Нэгдсэн Улсад 55, БНСУулсад 25, Канад улсад 3/</p>	100

						<p>Иргэдэд тоон гарын үсэг олгосноор төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia.mn/-д нэвтэрч, төрийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн. Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор ХААН банктай хамтран аян зохион байгуулж тоон гарын үсэг олгох программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэн пин код солих, өмнөх тоон гарын үсгийн мэдээллийг хүчингүй болгох зэрэг функцуудыг "Тридум кэй" ХХК-тай хамтран нэвтрүүлсэн.</p> <p>2023.12..10-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 948,668 иргэнд хүсэлт гаргаснаас</p> <p>-Иргэний үнэмлэхэд 763,597</p> <p>-Гар утасны аппликэйшнаар 185,134 тоон гарын үсэг олгосон байна.</p>	
1.4	Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлж, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийх, хэвлэх	1.530,1 сая.төг	Шинэчилсэн загвараар иргэний үнэмлэх олгосон хувь	1	10	<p>Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг боловсруулж, ХЗДХЯ-нд хүргүүлсэн бөгөөд хуулийн төсөл УИХ-ын 2022.06.03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсанаар хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах, иргэний регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн мэдээлэл зэргийг иргэний үнэмлэхийн санах ойд байршуулж, иргэний талаар ямар нэг мэдээлэл агуулаагүй, дахин давтагдахгүй иргэний бүртгэлийн дугаарыг ил харагдах бичилт хийх, төрийн байгууллагын үйлчилгээг авахад</p>	100

					<p>иргэний бүртгэлийн дугаарыг ашиглах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг Монгол Улсын Засгийн газрын 2022.10.10-ны өдрийн "Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, загварыг шинэчлэн батлах тухай" 374 дүгээр тогтоолоор батлуулж, иргэний бүртгэлийн 12 оронтой дугаарыг регистрийн дугаарын оронд ил харагдах байдлаар оруулж шинэчилсэн загварын иргэний үнэмлэхэд бичилт хийх ажлыг 2022.12.13-ний өдрөөс эхлүүлсэн бөгөөд 2023.12.10-ны өдрийн байдлаар 273,410 иргэнд иргэний үнэмлэх олгосон байна.</p> <p>Төрийн мэдээлэл солилцооны /ХУР/ систем дэх улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж буй бүх сервист өөрчлөлтийг оруулж, төрийн болон бусад байгууллага иргэний улсын бүртгэлийн дугаараар мэдээлэл авах боломжтой болсон. Мөн шинэ төрсөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын харьяат болсон иргэний улсын бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд хөтөлж, баталгаажуулсан тухай бүр мэдээллийн сангаас иргэний бүртгэлийн дугаарыг шууд олгож, харин иргэний харьяаллыг сэргээн тогтоосны бүртгэл хөтөлсөн тохиолдолд тухайн иргэний иргэний бүртгэлийн дугаарыг мэдээллийн сангаас шууд сэргээж, ашиглах боломжтой болсон. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай</p>
--	--	--	--	--	--

						хуулийн дагуу иргэнд иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан цахим шуудангийн хаягийг нээсэн. Ингэснээр хуулийн хэрэгжилтийг хангаж, хүний хувийн мэдээллийг хуулийн дагуу хамгаалах боломжтой болсон. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг иргэн иргэний бүртгэлийн дугаарыг ашиглан шалгах боломжийг бүрдүүлэн, программын хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн.	
1.5	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	3	10	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх загварчлал боловсруулан "Их өгөгдөл" ашиглан дүн шинжилгээ хийсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/953 дугаар тушаалын хавсралтаар "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-10 маягт/-д өөрчлөлт оруулан, "Түрээсийн гэрээ"-г эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-14 маягт/", "Түрээсийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-15 маягт/-г шинээр батлан мөрдөж ажиллаж байна. Маягтын загварыг шинэчлэн, өөрчлөн батлуулахын тулд "Түрээсийн гэрээ"-ний бүртгэл болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийх бүртгэлд өгөгдлийн шинжилгээ хийсэн.	100

						Мөн Нийслэлийн Дунжингарав ННУТ, Нийслэлийн улсын бүртгэлийн үйлчилгээний 4 (Сэлбэ, Алтай, 5 буудал, Дэнжийн 1000)цэгт -ийн, Баян-Өлгий, Сэлэнгэ, Дорнод, Өмнөговь, Архангай аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгчид ногдох бүртгэлийн тоо, бүртгэл хөтөлж байгаа цаг, ачаалал тооцон өгөгдлийн шинжилгээг тус тус хийсэн.	
1.6	Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх		Улсын бүртгэлийн Цахим машин дахь үйлчилгээний тоо	22	50	Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг ДӨТ машинаар үзүүлэхтэй холбоотойгоор гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээний талаар "Нью компас" ХХК-ийн холбогдох албан хаагчтай 2023.04.12-ны өдөр уулзалт зохион байгуулж, холбогдох саналыг хүргүүлсэн. ДӨТ машинаар гадаад паспорт болон иргэний үнэмлэх дахин авах болон шилжилт хөдөлгөөний бүртгэлийг үзүүлэхээр холбогдох хөгжүүлэлтийг хийлгэсэн. Хаан банкны КИОСК төхөөрөмжөөр дамжуулан иргэний үнэмлэхийн мэдээллээс тоон гарын үсгийг унших, таньж баталгаажуулах ажлын хүрээнд иргэний үнэмлэхтэй харьцах DLL програмыг боловсруулсан. Үүрэн холбооны 4 оператор болон банкнууд тоон гарын үсгийн сервистэй холбогддог болсон.	100
			Тоон гарын үсэг олгох бусад байгууллагын цахим /киоск/ машины тоо	0	1200	Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний 67 ширхэг ДӨТ машиныг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, программ хангамжийг суулгаж, бүх тохиргоог хийж, шаардлагатай нэгжүүдэд хуваарилж, ашиглалтад оруулан анхан шатны	

						<p>нэгжүүдэд байршуулан, 26 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:</p> <p>Лавлагаа-18 /Иргэний улсын бүртгэл-12, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-4, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-2/ Үйлчилгээ-8 /Иргэний улсын бүртгэл-4, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-3/ Мөн гадаад паспорт захиалах зориулалт бүхий 10 ширхэг ДӨТ машины программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн бөгөөд угсралтын ажил хийгдэж байна. Монгол улсын иргэдэд үнэ төлбөргүй олгох тоон гарын үсгийг бусад байгууллагын 1270 ширхэг цахим /киоск/ машинаар олгодог болсон. Үүнд:</p> <p>Гэрэгэ системс ХХК-385 Голомт банк АТМ-аар -270 ХААН банкны АТМ-аар-480 ТҮЦ-135</p>	
1.7	Улсын бүртгэлийн Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, сурталчлах	-	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн сурталчилгааны тоо	5	5	Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлан мэдээллийн хэрэгслээр дамжуулан 103 /гаруй/ удаагийн мэдээлэл хүргэсэн байна. Үүнээс телевизэд 56 удаагийн, сайтад 39 гаруй /давхардсан тоогоор/ удаа, сонинд 2 удаа буюу Зууны мэдээ сонин болон Өдрийн сонинд цаг үеийн холбогдолтой тодруулга ярилцлага өгч, мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.	100
			Боловсруулсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийн тоо	5	4	Тайлант хугацаанд 6 хууль, 11 журам, 2 стандартын төсөлд санал хүргүүлэн ажилласан. Үүнд: - Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах тухай анхдагч хуулийн	

						<p>төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд;</p> <p>- Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд;</p> <p>- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаас ирүүлсэн 2023 оны 3/827 дугаар албан бичгийн дагуу хуулийн төсөл /Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай/;</p> <p>- Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон нэмэлт, өөрчлөлт орох хуулийн төсөл;</p> <p>- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;</p> <p>- "Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зохицуулалтын талаар" Засгийн газрын тогтоолын төсөл, "Энгийн гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам"-нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, "Иргэний улсын бүртгэл хөтлөх журам", Засгийн газрын тогтоолын төсөл;</p> <p>- "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж, бүртгэх тухай журам"-ын нэмэлт, өөрчлөлтийн төсөл;</p> <p>- "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсгийг хүчингүй болгох тухай тогтоолын төсөл;</p> <p>- "Байгаль орчны мэдээллийн магадалгаа, нотолгооны байгууллагад</p>
--	--	--	--	--	--	---



						<p>тавих ерөнхий зарчим ба шаардлага" стандартын төсөл;</p> <ul style="list-style-type: none"> <li>- "Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам"-ын шинэчилсэн төсөл;</li> <li>- "Төсвийн байгууллагын дагаж мөрдөн нягтлан бодох бүртгэлийн журам"-ын төсөл;</li> <li>- "Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулга, түүнтэй холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын төсөл;</li> <li>- "Кибер халдлага, зөрчлийн мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам"-ын төсөл;</li> <li>- "Жендэрийн Дэд Зөвлөлийн ажиллах журам";</li> <li>- "Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд ажиллах журам";</li> <li>- Улсын бүртгэлийн байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д тус тус нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан.</li> </ul>	
<b>Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.</b>							
2.1	"Улсын бүртгэлийн үйлчилгээний төв"-ийн тоог нэмэгдүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагын тусламж дэмжлэг	Нэмэгдсэн улсын бүртгэлийн цэгийн тоо.	10	12	<p>Засгийн газрын 2023.05.03-ны өдрийн 167 дугаар тогтоолоор орон тооны хязгаар 146 болж батлагдан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023.05.23-ны өдрийн А/176 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтэц өөрчлөлт орсонтой холбоотойгоор Нийслэлийн улсын бүртгэлийн газрын 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтыг Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон цэгийн зохион байгуулалтад оруулж нийт 28</p>	100

						<p>үйлчилгээний төв болон цэгээр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. Нийслэлийн хэмжээнд 2023 онд шинээр 9 цэг /Баянзүрх дүүргийн "Жуков" цэг, Чингэлтэй дүүргийн "Дэнжийн 1000" цэг, "5 буудал" цэг, Баянгол дүүргийн "Алтай" цэг, "Бичил" цэг, Сонгинохайрхан дүүргийн "Өнөр" цэг, "Толгойт" цэг, Сүхбаатар дүүргийн "Их тойруу" цэг, Хан-Уул дүүргийн "Академи" цэг/-ийг тус тус шинээр нээсэн бөгөөд 6 НҮНТ, 22 "Улсын бүртгэлийн нэг цэг" иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.</p>	
2.2	<p>Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-mongolia, E-business/-аар үзүүлэх бүртгэлийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх</p>	-	<p>Нэмэгдсэн үйлчилгээний төрөл, тоо</p>	90	105	<p>Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/-д 105 үйлчилгээ нэвтрүүлэхээс 107 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2023.02.08-ны өдөр зохион байгуулсан И-Бизнесийг хөгжүүлэх, цахимаар хуулийн этгээдийг бүртгэхтэй холбоотой асуудлаар ЦХХХЯ, Голомт банк хамтран мэдээлэл солилцон гурван талт уулзалт хийсэн. "E-Business" төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар хуулийн этгээдийн 23945 үйлчилгээ, 8261 лавлагааг иргэн, хуулийн этгээдэд олгосон байна. E-mongolia портал системийн 3.0 шинэ хувилбар нэвтрэхтэй холбоотой дараах сервисүүдийг гаргаж өгсөн. Үүнд:</p>	100

						<p>1. Иргэний үнэмлэхийн дуусах хугацаа 30 хоногийн өмнө мэдэгдэх сервис</p> <p>2. Гадаад паспортын хүчинтэй хугацаа 180 хоногийн өмнө мэдэгдэх сервис</p> <p>3. Гадаад паспортын бичиг баримт харуулах хэсгийн сервис.</p> <p>"E-Mongolia, E-Business" төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар 10,959,863 лавлагаа, үйлчилгээг иргэн, хуулийн этгээд авчээ. Үүнээс:</p> <p>Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 7,973,001 лавлагаа, үйлчилгээ, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2,558,097 лавлагаа, үйлчилгээ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 428,765 лавлагаа, үйлчилгээ, англи хэл дээр 407,787 лавлагаа тус тус олгожээ.</p>	
2.3	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжид шилжүүлэх	ADB төсөл	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа сум, хорооны тоо	20	280	<p>Аймаг, нийслэлийн сум, хороонд оршин суугаа иргэдийн цаг хугацаа, зардал хэмнэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй шуурхай болгоход эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг нэмэгдүүлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд нийслэлийн Баянгол, Баянзүрх Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт оршин байгаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн шилжилт, эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны /ипотек/ гэрээ, барьцаалбар, барьцааны гэрээ дуусгавар болгох, мэдээллийн сангаас лавлагаа олгох зэрэг бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэж эхэлсэн.</p>	80.7

						<p>Эрх зүйч мэргэжилтэй сумдын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх практик сургалтыг зохион байгуулж, сумын 3, хорооны 7 улсын бүртгэгчид хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх, 19 аймгийн 61 сумын улсын бүртгэгчид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрхийг тус тус олгосон.</p> <p>Барьцааны гэрээний бүртгэлийг онлайнаар хийх системийг аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтэст хэрэглээнд нэвтрүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023.05.23-ны өдрийн А/176 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтэц өөрчлөлт орсонтой холбоотойгоор хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагтай болж Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн 71 орон тоон дээр 33 улсын бүртгэгч нэмэгдэж нийт 104 болж, хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн 8 орон тоон дээр 43 улсын бүртгэгч нэмэгдэж нийт 51 болж үйлчилгээний бүх төвүүдэд ажиллаж байна.</p>	
2.4	Эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн системийг шинэчлэх.	ADB төсөл	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг шинэчлэх хувь	0	60	<p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг шинэчлэх төслийн ажил энэ онд эхлээгүй байгаа боловч EPRS системд өөрчлөлт оруулах шаардлагатай өгөгдөл болон засварлах шаардлагатай цэсийн нийт 18 жагсаалтыг гарган ажиллаж байна.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумдад үзүүлсэнээр төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах, улсын бүртгэлийн бүхий л үйлчилгээг</p>	70

						сумдад хүргэх зорилтын хүрээнд 2023.07.24-ний өдөр Азийн хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, 2023.10.17-ны өдөр төсөл хэрэгжүүлэх санамж бичигт 2 тал гарын үсэг зурсан. Энэ санамж бичгийн хүрээнд 2023 оны 12 дугаар сараас 2025 оны 12 дугаар сарыг дуустал 2 жилийн хугацаанд Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй төсөл хэрэгжинэ.	
			Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим систем /eRS/-ийг шинэчлэх хувь	0	80	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим систем /eRS/-ийг шинэчлэх төсөл хэрэгжиж эхлээгүй байгаа боловч системд тусгах, тулгамдсан асуудлаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн ажиллаж байна.	
2.5	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх /blockchain/	-	Цахим хэлбэрээр олгосон газар өмчлөх эрхийн болон үл хөдлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ	0	25	Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа, холбооны яаманд тус тус хүргүүлж, бусад хуулийн төсөлд оруулах өөрчлөлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдсанаар эрх зүйн орчин бий болж, Эрхийн улсын бүртгэлийн систем /ePRS/-ийн шинэчлэлийн хүрээнд газар өмчлөх эрхийн болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын	70

						бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох нөхцөл бүрдэх болно.	
2.6	Нотариатч, мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх.	-	"Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээ"-г шинэчлэн байгуулсан нотариатчдын тоо;	0	30	Улсын бүртгэлийн ерөнхий газар Монголын нотариатчдын танхимын гишүүн нотариатч нар дундын мэдээллийн сангаар дамжуулан мэдээлэл солилцон ажиллаж байна. Нотариатч мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр хуулийн шаардлага хангасан мэдүүлэг, холбогдох баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд илгээх, бүртгүүлэхэд зуучлах үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Монголын Нотариатчдын танхимын ерөнхийлөгч Ч.Баянжаргал нар 2023.11.22-ны өдөр Мэдээлэл нийлүүлэх, мэдээлэл авах гэрээг байгуулсан.	100
			Нотариатчаар зуучлуулан бүртгэсэн бүртгэлийн тоо.	0	20	Үүний үндсэн дээр одоогийн байдлаар Монголын нотариатчдын танхимын 89 нотариатчтай мэдээлэл солилцох гэрээг байгуулсан. Монголын нотариатчдын танхим болон "Интерактив" ХХК нотариатын зуучлалын системийг хөгжүүлж байгаа ба УБЕГ-аас API болон орчны тохиргооны мэдээлэл, шаардлагатай сервисүүд, нэвтрэх нэр, нууц үгийг үүсгэж өгсний дагуу системийг ашиглахад бэлэн болоод байна.	
2.7	Барьцааны гэрээний болон барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар бүртгэх системийн	-	Цахимаар бүртгүүлэхээр системд холбогдсон банк, санхүүгийн байгууллагын тоо;	1	5	Монголын Банкны Холбоо, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, "МИК ОССК" ХХК болон "ҮЦСК" ХХК зэрэг 5 байгууллагын төлөөлөлтэй 2023 онд уулзаж Барьцааны гэрээний бүртгэлийг онлайнаар бүртгэх ажлыг эхлүүлэхэд шаардлагатай системийн	70

	хэрэглээ, цахим хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх.		Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээний бүртгэлийн тоо;	16	100	тодорхойлолт, хөгжүүлэлтийн мэдээлэл болон цахим барьцааны бүртгэлийн ерөнхий ойлголтын талаар мэдээлэл солилцсон. Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк болон МИК ОССК ХХК-ийн системийн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлснээс МИК ОССК ХХК-ийн систем бэлэн болж нийт 3 барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг цахимаар хүлээн авч бүртгэсэн. Мөн Голомт банкнаас онлайнаар ирүүлсэн 3 барьцааны гэрээ, 2 барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг хүлээн авч бүртгэсэн бөгөөд хуулийн шаардлага хангаагүй 2 барьцааны гэрээний мэдүүлгийг хүлээн авахаас татгалзан буцааж шийдвэрлэсэн.	
			Цахимаар бүртгэсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийн тоо	3	100		
2.8	Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах, өөрчлөлт оруулах, хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх.	-	Газар, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дундын мэдээллийн сан үүсгэж, өөрчлөлт оруулсан хувь	0	60	"Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан"-г байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/82, А/985 дугаар тушаалаар байгуулсан. 2023 онд нийслэлийн Чингэлтэй дүүрэг, орон нутагт Төв аймгийн Баянчандмань сумын мэдээллийг кадастрын дугаар, хаягийн мэдээллээр тулгахад Чингэлтэй дүүрэгт 43.7%, Баянчандмань суманд 53.9%, Дундговь аймгийн Сайнцагаан суманд ажилласан бөгөөд нэгж талбарын дугаартай нийт 10350 бүртгэлийн хаягийн мэдээллийг ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн 11675 хаягийн мэдээлэлтэй шинэ нэгж талбарын	100
			Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн хувь	0	70		

					<p>дугаараар тулгалт хийхэд 4150 мэдээлэл таарсан.</p> <p>Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 11/А/46 дугаартай тушаалаар шинэчлэн байгуулагдсан "Хаягийн мэдээллийн системийг нэвтрүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг судлан тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах, салбар хоорондын уялдааг ханган хамтран ажиллах" үүрэг бүхий ажлын хэсэгт ЭХЭУБГазрын дарга гишүүнээр ажиллаж байна.</p> <p>Хаягийн нэгдсэн мэдээллийн санг газрын нэгж талбарын дугаарт суурилан, хуучин, шинэ хаягийг зэрэгцүүлсэн байдлаар үүсгэхээр Улсын бүртгэлийн ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт байгаа хаягийн мэдээллийг тулгах ажил хийгдсээр байна. Уг ажлын хүрээнд хоёр байгууллага хоёр талаасаа мэдээллийн сан үүсгэн улсын бүртгэлийн байгууллагаас орон нутгийн кадастрын дугаартай 566822 бүртгэлийн жагсаалтыг, ГЗБГЗЗГ аас ирүүлсэн 540364 мэдээллийг байрлуулсан бөгөөд Үндэсний Дата төвд байрлах сервер дээр нэмж дундын мэдээллийн сангийн бүтэц, өгөгдлийн хүснэгт, баганы мэдээллийг оруулахаар тохиролцон ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр</p>
--	--	--	--	--	--



						<p>мэдээлэл солилцохдоо хуульд заасан хязгаартай мэдээллийг тухайн байгууллагын үндсэн чиглэл, үйл ажиллагаанд нийцүүлэн "Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам"-ийн дагуу төрийн 125, хувийн хэвшлийн 313 байгууллага нийт 438 байгууллагат 173 төрлийн сервис үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>Эрүүл мэндийн яамны төрөлт, ГЗБГЗЗГ-ын Э, А дугаарын мэдээллийг солилцох сервисийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. 2023.12.10-ны өдрийг хүртэл 62,114 иргэнд регистрийн дугаар, газрын эзэмших гэрчилгээ 63,715 дугаар, ашиглах гэрчилгээ 993 дугаар тус тус олгосон байна</p> <p>Тайлант хугацаанд газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг дундын мэдээллийн сангаас автоматаар олгодог болсон бөгөөд 2023.12.10-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 64,708 дугаар дундын мэдээллийн сангаас олгосон байна.</p>
2.9	Иргэний үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох технологи /NFC/-ийг нэвтрүүлэх ажлыг судалж, үе шаттай хэрэгжүүлэх	-	Иргэний үнэмлэхийн хэрэглээ нэмэгдэж, боловсронгуй болсон хувь	0	1	<p>Монгол Улсын иргэний цахим үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох /NFC/ технологийг нэвтрүүлэхтэй холбоотой "Смарт карт" ХХК-ийн холбогдох албан хаагчидтай уулзах уулзалтыг 2023.10.17-ны өдөр зохион байгуулж, үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт загварыг шинэчлэн батлах тухай" 374 дүгээр тогтоолд</p>

						<p>нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор танилцуулга, тогтоолын төслийг бэлтгэн газрын даргад танилцуулж, 2023.11.21-ны өдрийн н/79 тоот албан бичгээр ХЗДХЯ хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган иргэний цахим үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох /NFC/ технологийг хөгжүүлэх техникийн шийдэл, холбогдох системийн өөрчлөлтүүдийг хийж, 2023.12.20-ны өдрөөс хэвлэж эхлэхээр бэлтгэл ажлыг хангасан. Ингэснээр иргэний цахим үнэмлэхийг хосолсон холболтын интерфэйстэй болгож, цаашид төрийн болох хувийн хэвшлийн байгууллага иргэний үнэмлэхийг ашиглан харилцан мэдээлэл солилцох боломжийг бий болгосон.</p> <p>Иргэний үнэмлэх хэвлэх үйлдвэрийн Datacard MX2100 хэвлэх төхөөрөмжид шинэ загварын NFC цахим иргэний үнэмлэхийн бэлдэц ашиглан хэрэглээнд нэвтрүүлэх тохиргоог хийж туршсан. Шинээр нийлүүлэгдсэн Contactless чиптэй иргэний үнэмлэхийн бэлдцэд бичилт хийх бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв.</p>	70
2.10	Үндэсний энгийн гадаад паспортын бэлдэцийг бэлтгэх, бичилтийн ажлыг хэвийн, тасралтгүй явуулах, тухайн үйлдвэртэй холбоотой ажлыг зохион байгуулах	18,000 сая төгрөг	Бэлдэц болон паспорт алдаагүй бичилт хийгдсэн тоо	44778	300 000	<p>Засгийн газрын 2023.02.08-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц үйлдвэрлэх, бичилт хийх "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлагдсан. "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал</p>	100

					<p>хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 51 хувийн хувьцаа эзэмшигчээр, "Мигасон" ХХК нь 49 хувийн хувийн хувьцаа эзэмшигчээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023.04.11-ны өдөр "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК бүртгэгдсэн.</p> <p>"Мигасон" ХХК-тай 2023 онд байгуулсан "Гадаад паспортын бэлдэц нийцүүлэх гэрээ", "Смарт карт" ХХК-тай байгуулсан "Монгол Улсын иргэний үнэмлэхийн бэлдэц нийлүүлэх гэрээ"-ний дагуу бэлдцийг хүлээн авах Ажлын хэсэг байгуулан гэрээний дагуу бэлдцийг хүлээн авч ажиллаж байна.</p> <p>2023.12.10-ны өдрийн байдлаар нийт гадаад паспортын 439,200 ширхэг бэлдцийг хүлээлгэн өгснөөс энгийн гадаад паспортын бэлдэц 139,700 ширхэг, цахим гадаад паспортын бэлдэц 299,500 ширхэг байна.</p> <p>2023.03.01-2023.12.10-ний өдөр хүртэл "Хэвлэх үйлдвэр"-т шинэ бэлдцээр хэвлэгдсэн нийт 410,694 паспорт байна. Үүнээс энгийн гадаад паспорт 134,776, цахим гадаад паспорт 275,918 байна.</p> <p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хэвлэх үйлдвэр иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлэн, шинэчилсэн загвар бүхий бэлдцэд бичилт хийж, 2023.12.10-ны өдрийн байдлаар 273,410 иргэний үнэмлэх хэвлэж, 585,634 үндэсний энгийн гадаад паспортын бичилтийг хийсэн байна.</p>
<p>Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.</p>					

3.1	Хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-ыг нууцлал бүй сүлжээ /VPN/-д холбож, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн онлайн системд холбох	-	Сүлжээнд холбосон ДТГын тоо	5	10	Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарын санаачилгаар гадаад улсад оршин сууж байгаа Монгол Улсын иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай үзүүлэх, тоон гарын үсэг олгох зорилгоор 2022.11.26-ны өдрөөс 2022.12.22-ны өдрүүдэд Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яам, Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайдын яам, Америкийн Нэгдсэн Улсад суугаа Элчин сайдын яам, Сан-Франциско дахь Ерөнхий Консулын газар, Чикаго дахь Консулын газар, 2023.07.03-ны өдрөөс БНСУ-ын Пусан хот дахь Консулын газар, 2023.11 дүгээр сарын 13-ны өдрөөс 17-ны өдрүүдэд БНУУ-ын Будапешт дахь Элчин сайдын яамны офлайн мэдээллийн санг холбох ажлыг зохион байгуулж ажилласан. Ингэсэнээр нийт 7 газрыг холбосон бөгөөд энэ оны 12 дугаар сард багтаан Монгол Улсаас БНХАУ, ОХУ-д ажиллаж байгаа ДТГ-ын бүртгэлийн ажилтны офлайн санг иргэний улсын бүртгэлийн онлайн мэдээллийн санд холбохоор төлөвлөн ажиллаж байна. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд иргэний улсын бүртгэлийн 21 төрлийн лавлагаа олгох, төрсний, эцэг /эх/ тогтоосны, гэрлэсний, гэрлэлт сэргээсний, гэрлэлт дуусгавар болсны, нас барсны, биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/, иргэний үнэмлэхийн, гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг шууд үзүүлэх боломжтой болсны зэрэгцээ иргэдэд тоон гарын үсэг олгосноор төрийн цахим	100
-----	---	---	-----------------------------	---	----	--	-----

						<p>үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia.mn/-д нэвтэрч, төрийн байгууллагын бусад үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлсэн. Иргэний улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбосон нийт 7 бүртгэлийн ажилтанд холбогдох эрхийг нээсэн. Ингэснээр дээрх газруудад хөтөлсөн нийт 6148 бүртгэлийн 5247 буюу 85,34 хувийг онлайн мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулсан.</p> <p>Хилийн чанадад ажиллаж байгаа ДТГ-ын бүртгэлийн ажилтанд 6 удаагийн сургалтыг цахимаар, 2 удаагийн сургалтыг танхимаар зохион байгуулж, 5 удаагийн чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар иргэний үнэмлэх 1176 ширхэг, үндэсний энгийн гадаад паспорт 5940 ширхэг хэвлүүлэн хүргүүлсэн.</p>	
3.2	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах	-	Эрсдэлийн төлөвлөгөөний биелэлт, хувиар	30	100	<p>УБЕГ-ын даргын баталсан "Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ажлын ерөнхий төлөвлөгөө"-нд тусгагдсан улсын бүртгэл хөтлөх эрсдэлийн 6 ангилалын 55 эрсдэлийг бууруулах арга хэмжээг УБЕГ-ын газар, хэлтсүүд хамтран хэрэгжүүлж ажиллав.</p> <p>"Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ажлын ерөнхий төлөвлөгөө"-ний биелэлтийг гаргаж, УБЕГ-ын даргад танилцуулав.</p>	100

3.3	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг үнэлж, дүгнэлт гарган, мэдээллийн санг цэгцлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	42.5	100	Монгол Улсын иргэний улсын бүртгэлийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлж, цахим гадаад паспорт хэвлэх, паспортад бичилт хийх, олон улсын стандарт шаардлага хангасан дэд бүтэц /бүртгэлийн программ хангамж, техникийн хангамж, мэдээлэл дамжуулах сүлжээ/-ийг бий болгосон. УБЕГ-ын даргын 2022 оны А/1146 тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг УБЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/1717 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх ажлын ерөнхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд иргэний улсын бүртгэлийн 14, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 5, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 21, улсын бүртгэлийн нэгдсэн архивын 4, хүний нөөцийн 3 нийт 47 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажилласан. Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд алдаатай, давхардсан, зөрүүтэй, бүртгэгдээгүй, зөрчилтэй нийт 1.019.487 алдаа, зөрчлийг арилгаснаас, иргэний улсын бүртгэлийн 47225, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 303800, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 287215, улсын бүртгэлийн нэгдсэн архивын 381247 алдаа, зөрчлийг арилгаж, мэдээллийн сангийн мэдээллийг цэгцэлсэн байна.	100
3.4	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний	100	100	Улсын бүртгэлийн хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөөг батлан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	100

	тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах		хэрэгжилтийн хувь			<p>ажлын хүрээнд Увс, Говьсүмбэр, Дорноговь, Орхон аймгуудын Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны улсын бүртгэл хөтөлсөн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт, нийслэлийн Хан-Уул дүүрэг, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд гүйцэтгэлийн шалгалтыг хийж, шалгалтаар илэрсэн улсын бүртгэлийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлагыг тус аймгуудын Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж зөрчлийг арилгаж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь гэрлэсний болон гэрлэлт дуусгавар болсны бүртгэл нь 2-оос дээш бүртгэлтэй 393 бүртгэлд хяналт тавьж, хяналтын улсын байцаагчийн 2 удаагийн дүгнэлтээр 237 иргэний зөрчил;</li> <li>- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 3873 хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийг шалгаж, 112 зөрчил;</li> </ul> <p>УБЕГ-ын даргын баталсан "Улсын бүртгэлийн архивын эх нотлох баримтын хадгалалт, хамгаалалт, цахимжуулах ажиллагаанд хяналт тавих" шалгалтын удирдамжийн дагуу иргэний улсын бүртгэлийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын эх нотлох баримтын баяжилт, цахимжуулах үйл ажиллагаанд 2023.01.02-ны өдрөөс 2023.11.03-ны өдрийн хугацаанд бүртгэгдсэн эх нотлох</p>
--	---	--	----------------------	--	--	---

						баримтад шалгалт хийж, иргэний улсын бүртгэлийн 12251, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 69, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 461, нийт 12781 зөрчлийг илрүүлсэн. Шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар хяналтын улсын байцаагчийн албан шаардлагыг НУБГ-т 1, ИУБГ, ХЭУБГ, ЭХЭУБГ-т 3 мэдэгдлийг тус тус хүргүүлж, өнөөдрийн байдлаар иргэний улсын бүртгэлийн 116, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 50, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1115, нийт 1281 зөрчлийг арилгасан байна.	
3.5	Бодлогын баримт бичиг болон захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	-	Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тоо;	7	12	Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050"-ын эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн, даргын зөвлөлийн хуралд танилцуулан, <a href="http://www.mojha.unelgee.gov.mn">www.mojha.unelgee.gov.mn</a> цахим системд оруулж баталгаажуулсан. "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилт, "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний эхний хагас жилийн тайлан, "Хууль тогтоомж, тогтоол шийдвэр"-ийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 1/5555 тоот албан бичгээр ХЗДХЯ-ны ХШҮДАГ-т, 2023 оны 7-10 дугаар сарын тайланг удирдлагад танилцуулан	100
			Хүргүүлсэн зөвлөмжийн тоо.	2	2		
			Эрсдэлийн бууралтын хувь	6	8		



						<p>2023.08.02, 2023.09.05, 2023.10.02, 2023.11.08-ны өдөр тус тус ХЗДХЯ-ны ХШУДАГ-т ахлах мэргэжилтэн Т. Төмөр-Очир, ЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн Т.Зул нарт цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>Мөн явцын хяналтыг 2022 оны 07 сараас эхлэн 2023 оны 6 дугаар хүртэл сар тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн удирдлагад танилцуулан, <a href="http://www.mojha.unelgee.gov.mn">www.mojha.unelgee.gov.mn</a> цахим системд цаг тухай бүр байршуулан ажиллаж байна. Эхний хагас жилийн үнэлгээний мөрөөр газруудад 1 зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаа.</p> <p>21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.</p> <p>Эхний хагас жилийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай, Улсын бүртгэлийн ерөнхий газрын шуурхай, Даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл ажиллагаанд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгжүүдэд зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
3.6	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой	-	Шилэн дансны хуулийг хэрэгжилтийн хувь	99.6	100	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 147 мэдээллийг үнэн зөв гаргаж тогтоосон хугацаанд шилэн дансны цахим хуудас болон төвлөрүүлэн захирагчийн цахим хуудсанд сар бүрийн 05-ны өдрийн	100
			Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо.	3910	3910		

	зарцуулах, тайлагнах, байршуулах, санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх					дотор байршуулан ажилласан. Улсын бүртгэлийн байгууллагын 23 нэгж нь Төсвийн шууд захирагчийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн санд байршуулж байгаа бөгөөд 2023 оны 04 дүгээр сараас эхлэн УБЕГ нь Төсвийн төвлөрүүлэн захирагчаар нэмэлт мэдээлэл байршуулж байна. Шилэн дансны нэгдсэн санд байршуулсан мэдээлэл бүрийг улсын бүртгэлийн байгууллагын албан ёсны цахим хаяг болох <a href="http://burtgel.gov.mn">burtgel.gov.mn</a> -д тухай бүр байршуулж байна.	
3.7	Үндэсний аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын тоо, биелэлтийн хувь	100	100	Улсын бүртгэлийн байгууллагын 23 нэгжийн 2022 оны санхүүгийн тайлангийн үйл ажиллагаанд төрийн аудитын байгууллагын дүгнэлтээр 23 нэгж "өөрчлөлтгүй дүгнэлт" авсан ба 5 нэгж ямар нэгэн алдаа, зөрчилгүй, 18 нэгж 2 акт, 10 албан шаардлага, 28 зөвлөмж бүхий нийт 222,855.0 алдаа зөрчил илэрснийг хяналтад авч ажиллаж байна. Санхүүгийн 2022 оны тайлангийн аудитаар 22 нэгж нь зөрчилгүй дүгнэлт авсан нь 2021 онтой харьцуулахад / 2021 онд 47 зөрчилд 450,1 сая төгрөгийн зөрчил илэрч байсан бол / 2022 он 31 зөрчилд 72,2 сая төгрөгийн зөрчил илэрч урд оноос 16 төрлийн буюу 377,9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 23 нэгжийн 2022 оны санхүүгийн аудитын тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яам болон Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газарт тус тус цахимаар хүргүүлсэн.	100

						<p>Улсын бүртгэлийн байгууллагын 23 нэгжээс 18 нэгж 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр 40 тооны алдаа зөрчлийн биелэлтийг Төрийн аудитын нэгдсэн цахим сан fas.audit.mn-д байршуулж, гүйцэтгэлийг хянуулсан. Fas.audit.mn-д байршуулах сургалтыг ХЗДХЯ, ҮАГ-аас 06 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдахад нийт 23 нэгжийн ахлах нягтлан бодогч нарыг хамруулсан. 2023 оны зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацааны дотор бүх нэгжүүд fas.audit.mn-д байршуулж, тухайн орон нутгийн Төрийн аудитын газарт хүргүүлж, биелэлт 100 хувьтай байна. Холбогдох дотоод аудитын тайланг 03 дугаар сарын 29-ны 1/2932 албан бичгээр, 08 дугаар сарын 30-ны өдөр undraa@mojha.gov.mn цахим шуудан руу хавсралтуудын хамт тус тус хүргүүлсэн.</p> <p>2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитыг газрын аудитын код СНАГ-2023/19/НА-СТА-ТТ3 дүгнэлтийг үндэслэн 9 чиглэлийн дагуу арга хэмжээг авч ажилласан.</p>	
3.8	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах.	-	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэсэн эсэх;	82	84	<p>УБЕГ-ын даргын 2023 оны А/1698 дугаар тушаалаар Хэрэглэгчийн үнэлгээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан УБЕГ-ын 2023 оны үйл ажиллагаанд "Хэрэглэгчийн үнэлгээ" хийх ажлыг гүйцэтгүүлэхээр "Гранд Дата" ХХК -ыг сонгон шалгаруулж, 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 30-ны өдрүүдэд хийхээр гэрээ байгуулан хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлгэж дууссан. Үнэлгээний дүнд</p>	100

						Улсын бүртгэлийн байгууллагын 2023 оны үйл ажиллагааны чиглэл бүрээр нь үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээ нь 4.32 /86.4%/, 2022 оны үйл ажиллагаа нь 4.29 /85.8 %/, 2023 онд 0.03 пункт буюу 0.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан.	
3.9	Хуулийн этгээдийн архивын санг зориулалтын нягтруулсан шүүгээгээр шинэчилж сайжруулах	-	Шинээр суурьлуулсан нягтруулсан шүүгээний тоо	0	408	Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын сангийн нягтруулсан шүүгээг шинэчилж, 377 нягтруулсан шүүгээг шинээр Тамгын газрын архивт 16 нягтруулсан шүүгээг тус тус суурилуулж, өмнө нь хэрэглэж байсан 383 нягтруулсан шүүгээ, 22 төмөр тавиурыг орон нутагт хуваарилан шилжүүлсэн.	100
3.10	Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын баримтад сэдэвчилсэн тооллого хийх	-	Тооллого хийсэн эсэх	0	1	Хуулийн этгээдийн архивын баримтын сэдэвчилсэн тооллогод шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн баримтыг энэ онд тооллогод хамруулахаар сонгон, компани, нөхөрлөл, хоршоо, төсөвт байгууллагын 4316, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хэвлэл мэдээллийн байгууллагын 3074 хувийн хэргийг тооллогод хамруулаад байна. Тооллогын ажлын энэ онд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Ажлын явц 90 гаруй хувьтай хийгдэж байна.	100
<b>Зорилт 4. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.</b>							
4.1	Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	Төсөл, хөтөлбөр	АХБ банк болон КОЙКА олон улсын хамтын ажиллагааы нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо	0	2	Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих "Ухаалаг Засаг 2" төслийн хэрэгжилтийн талаарх Дэлхийн банк болон УБЕГ-ын хамтарсан уулзалтыг 2023.03.30-ны өдөр зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газраас төслийг соёрхон баталж албан ёсоор 2023.04.06-ны өдрөөс эхлүүлсэн. Тус төсөлд УБЕГ-аас хүргүүлсэн 3 төрлийн	100

				саналаас тоног төхөөрөмж техник хангамжтай холбоотой санал болон албан хаагчдын сургалтын санал дэмжигдсэн бөгөөд 2023 онд төслийн баримт бичиг буюу техникийн тодорхойлолтыг хүргүүлсэн. Тус төслийн хэрэгжилттэй холбоотойгоор Монгол улс дахь БНСУ-ын Элчин сайдын яамны төлөөлөлтэй 2023.04.24-ний өдөр уулзалт зохион байгуулсан. БНСУ-аас 2023.05.22-26-ны өдрүүдэд хөндлөнгийн үнэлгээний 5 хүний бүрэлдэхүүнтэй баг УБЕГ болон аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд төслийн хэрэгжилтэд үнэлэлт өгөх зорилгоор 5 хоногийн хугацаатай ажилласан ба үнэлгээний багийн ажиллах хөтөлбөрийг гарган хүргүүлж, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэн ажиллав. Мөн төслийн хүрээнд сургалтад хамрагдсан албан хаагчдын өнөөгийн ажил байдлын судалгааг гарган хүргүүлсэн ба шаардлагатай мэдээ мэдээллийг тухай бүрт гаргаж өгч ажиллаж байна.	
		Гадаадад туршлага судалсан, сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	10	20	БНЭУ-ын Энэтхэгийн Техник, Эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр (ИТЕС)-т 2023 оны 01 дүгээр сард Сонгогчдын боловсрол сэдэвт сургалтад 2, 2023 оны 08 дугаар сард зохион байгуулагдсан Дата өгөгдлийн сургалтад 1 нийт 3 албан хаагч тэтгэлэгт шалгаран амжилттай хамрагдсан. БНСУ-ын Солонгосын менежментийн зөвлөх нийгэмлэг (Korea Management Association Consulting/КМАС) компани болон Тогтвортой хөгжлийн хөтөч НҮТББ-тай хамтран 2023.01.30-ны

						<p>өдрөөс 2023.02.04-ний өдрүүдэд улсын бүртгэлийн байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр төрийн албан хаагчийн манлайллын хөтөлбөрт 14 албан хаагч хамрагдсан.</p> <p>Тайландын Хаант Улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан "Иргэний бүртгэлийн бүрэн байдлын тэгш бус байдлыг үнэлэх" бүсийн сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 15-ны өдрүүдэд 1 албан хаагч хамрагдсан.</p> <p>БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын санхүүжилтээр тус улсын шүүхийн харьяа Төрийн албан хаагчдын сургалтын төвөөс 2023-2025 онд хэрэгжүүлэх "Улсын бүртгэлийн системийн чадавхийг бэхжүүлэх" төслийн хүрээнд эхний шатны сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, удирдах түвшний 25 албан хаагч сургалтад хамрагдсан.</p> <p>БНХАУ-ын Шинжинь хотноо 2023.11. 28-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдах Олон улсын архивын консулын Зүүн азийн салбар /EASTICA/-ын 2023 оны ээлжит хуралдаанд УБНА-ын 2 албан хаагч оролцов.</p>	
4.2	Гадаадын төсөл, хөтөлбөр, ижил түвшний бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг тухай бүр	-	Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулсан байгууллага, төсөл, хөтөлбөрийн тоо,	2	3	<p>Монгол улс 2023.03.01-ний өдрөөс Үндэсний энгийн цахим гадаад паспортын захиалгыг авч эхэлсэн бөгөөд 2023.03.15-ний өдрөөс иргэдэд олгож эхэлсэн ба уг паспортын чипний баталгаажуулалт сайжруулалттай холбоотойгоор Олон улсын магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар</p>	100

	<p>боловсруулж, хэрэгжүүлэх</p>				<p>шалгуулан гэрчилгээжүүлэх ажлын хийгдсэн. Уг ажлын хүрээнд ИНСЕРТ байгууллагыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр сонгон ХБНГУ-ын "Фогра" компанитай хамтран шинжилгээ хийлгүүлэн хариуг 2023 оны 10 дугаар сард хүлээн авлаа.</p> <p>АХБ-ны санхүүжилтээр 2023-2025 онд хэрэгжих "Эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг сум, хороодод нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах" төслийн хүрээнд тус банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран ажиллах тухай "Санамж бичиг"-ийг 2023.10.17-ны өдөр үзэглэсэн.</p> <p>Гадаадын төсөл, хөтөлбөр ижил түвшний бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах зорилтын хүрээнд албан хаагчдын хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2023.06.30-ны өдөр Масс академитай хамтран ажиллах тухай Санамж бичгийг байгуулсан.</p> <p>ОХУ-ын Улсын Бүртгэл, Кадастр, Зураг зүйн газар /Росреестр/-тай 2017 онд хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулагдсан. Үүний хүрээнд хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэл дэх цахим шилжилтийн талаар санал солилцох тухай хамтарсан уулзалтыг 2023.10.24-ний өдөр зохион байгуулсан. Уулзалтад УБЕГ-ын ЭХЭУБГ-ын дарга Б.Ариунболд тэргүүтэй төлөөллүүд болон Росреестр-</p>
--	-------------------------------------	--	--	--	---

						ын орлогч дарга ноён Смирнов.М.С тэргүүтэй төлөөллүүд оролцсон.	
4.3	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбоотойгоор олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	-	Уулзалт зохион байгуулсан тоо	0	3	2023.09.04-ний өдөр БНХАУ-ын элчин сайдын яамны Соёлын төвийн захирал Ли Чжи болон холбогдох албаны хүмүүстэй ХЭУБГ-ын төлөөллүүдийн хамт Олон улсын гэрээгээр байгуулагдсан засгийн газар хоорондын байгууллага болон гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах талаар, 2023.09.14-ний өдөр олон улсын холбогдох байгууллагаас мэдээ, мэдээлэл авах боломжгүйгээс шалтгаалсан эрсдэлд хамтран ажиллах асуудлаар мөн 2023.10.04-ны өдөр Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Гишүүнчлэлийн газрын дарга Ц.Магнайбаатар тэргүүтэй албаны хүмүүстэй УБЕГ-ын ХЭУБГ болон ХШГ-ын төлөөллүүд "Улсын бүртгэл хөтлөхтэй холбоотойгоор олон улсын холбогдох байгууллагаас мэдээ, мэдээлэл авах" талаар нийт 3 удаагийн уулзалт зохион байгуулж, санал солилцлоо. Дээрхи асуудлын хүрээнд дэмжлэг хүсэх тухай 2023.09.14-ний өдрийн 1/8293 дугаар албан бичгийг ХЗДХЯ-нд, 2023.10.30-ны өдрийн 1/10007 дугаар албан бичгээр мэдээлэл хүсэж, хамтран ажиллах тухай ГХЯ-ны консулын газарт тус тус хүргүүлсэн.	100
			Хамтран ажилласан байгууллагын тоо	0	2	Энэ оны 12 дугаар сараас 2025 оны 12 дугаар сарыг дуустал 2 жилийн хугацаанд Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй төсөл хэрэгжинэ.	
<b>Зорилт 5. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.</b>							



5.1	Байгууллагын 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	98	100	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УБЕГ-ын сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхыг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хэрэгжилтийг хангаж, 2023 оны сургалтын төлөвлөгөөний хүрээнд 142 удаагийн сургалт зохион байгуулж 16345 (давхардсан тоогоор) албан хаагч хамрагдсан байна. Үүнээс улсын бүртгэлийн байгууллагын 101 удаагийн дотоод сургалтаар 15534 (давхардсан тоогоор) албан хаагч хамрагдсан бол Засгийн газрын болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулсан 35 удаагийн сургалтад 766 албан хаагч тус тус хамрагдсан.	100
5.2	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлэх, хуульд заасны дагуу холбогдох мэдээллийг цахим хуудаст байршуулах	-	Цахим сургалтын мэдээллийн баяжилтийг хийсэн хувь	80	100	Хүний нөөц, сургалтын программын Монгол бичгийн видео хичээл, цахим ном, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай видео хичээл, Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл дэд цэсийг нээж чиглэл, зөвлөмж, бүртгэл хөтлөх зааварчилгаа, видео заавар, сургалтын бичлэг, онлайн программд зураг хэрхэн оруулах тухай зааварчилгаа, бие даах хичээл болох ерөнхий мэдлэгийн хичээл, иргэний улсын бүртгэлийн хичээл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хичээл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хичээл, улсын бүртгэлийн нэгдсэн архивын хичээлийн 40 видео хичээл, цахим номыг нийт 8915 (давхардсан тоогоор) албан хаагч үзэж судалсан байна. 2023 оны 12 дугаар	100

						сарын 10-ны өдрийн байдлаар улсын бүртгэлийн ерөнхий шалгалтыг сургалтын нэгдсэн системд 1820 нийт албан хаагч цахим хичээл болон сургалтыг судалж, бататгах шалгалтыг өгсөн байна.	
5.3	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийг хариуцлагын даатгалд даатгуулах	-	Даатгалд хамруулсан хувь	0	100	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд даатгуулах ажлыг сонгон шалгаруулах хүсэлтийг ХЗДХЯ-нд хүргүүлсэн бөгөөд дотооддоо зохион байгуулах чиглэл ирүүлсэн. Үүний дагуу даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 3 хуулийн этгээдэд бүтээгдэхүүн үйлчилгээ, үнийн санал ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсэн бөгөөд 2 хуулийн этгээдээс санал ирүүлсэн. Нэгж улсын бүртгэгчийн хариуцлагын хязгаар 50,000,000 /тавин сая/ төгрөг байхаар тооцоолж нийт 240 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах судалгаа гаргаж, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн саналыг боловсруулсан. Даатгалын үйлчилгээний хураамж 2023 оны төсөвт тусгагдаагүй учир гэрээг байгуулаагүй байна.	50
5.4	Архивчдын нэгдсэн сургалтыг зохион байгуулах	-	Сургалт зохион байгуулсан эсэх	0	1	Улсын бүртгэлийн ерөнхий газрын нийт архивчдын нэгдсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, зардлыг шийдвэрлэн 2024 оны 1 дүгээр сард зохион байгуулна.	50
Дундаж үнэлгээ							92.96
Оноо							4.64